

ГИХГ-ЫН БУЯНТ-УХАА ДАХЬ ГАЗРААС 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 06 дугаар сарын 18

Буянт-Ухаа


Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Засгийн газрын 2010 оны 338, 340 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон иргэнд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2017 оны 12 дугаар сарын 11-ээс 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрүүдэд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Монгол Улсын виз, бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд нийт 118 орны 2052 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 185 хийсэн байна. Үүнд, нэг удаагийн орох 1643, хоёр удаагийн орох 2, олон удаагийн орох 80, нэг удаагийн гарах-орох 76, хоёр удаагийн гарах-орох 0, олон удаагийн гарах-орох 47, дамжин өнгөрөх 19, түр ирэгчийн бүртгэл 177, хасалт 177, оршин суух зөвшөөрлийн хасалт 53, визийн засвар 83, хүчингүй болгосон виз 8 байна.

Дээрх тоон үзүүлэлтийг 2017 оны мөн үетэй харьцуулахад орох виз олголт 27 хувиар, дамжин өнгөрөх виз олголт 4 дахин тус тус өссөн, харин гарах-орох виз олголт 15 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнийг графикаар харуулбал:




1.2. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Тайлант хугацаанд Монгол Улсын виз, визийн зөвшөөрөлгүй, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулах зэрэг үндэслэлээр Бангладеш 1, БНАСАУ 4, Кыргыз 1, Афганистан 1, Иран 1, ХБНГУ 1, БНСВУ 1, Канад 1, БНХАУ 1, Индонези 1, Аргентин 1, Филиппин 4, Болгар 1, БНЭУ 2, АБНСУ 1, Түвд 2, нийт 24 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан ба гарах визгүй, байгууллага, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр БНСУ 1, БНТУ 4, БНХАУ 1, Япон 1, Дани 1, Австрали 2, Польш улсын 1, БНФилУ-4, Япон-1, ХБНГУ-2, БНПУ-1, Сингапур-2, БНХАУ-6, Нигериа-1, АНУ 2, Балба 1, Индонези 1, Куба 1, нийт 33 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно.

Харин шүүх, прокурор, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.


Дээрх тоон үзүүлэлтийг 2017 оны мөн үетэй харьцуулахад Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан гадаадын иргэн 1 дахин буурсан, харин Монгол Улсын хилээр гаргаагүй гадаадын иргэн 1 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг графикаар харуулбал:



1.3. Захиргааны арга хэмжээ авсан талаар:

Тайлангийн хугацаанд бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 102 гадаадын иргэнд 14,850,000 төгрөг, 11 аж ахуйн нэгжид /хамрагдсан гадаадын иргэн 14/ 770,000 төгрөг, 2 уригч иргэний урьсан 2 гадаадын иргэнд 500,000 төгрөг, нийт 16,120,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.


Дээрх тоон үзүүлэлтийг 2017 оны мөн үетэй харьцуулахад торгуулийн арга хэмжээ авагдсан гадаадын иргэн 1 дахин буурсан үзүүлэлттэй байна. Үүнийг графикаар харуулбал:



1.4. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний талаар:

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн 4 орны 6 гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргасан. Үүнд: БНХАУ-ын 3, Япон Улсын 1, БНСУ-ын 1, Сири Улсын 1 иргэн байна.

Дээрх тоон үзүүлэлтийг 2017 оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг графикаар харуулбал:



1.5. Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын хүрээнд:

Буянт-Ухаа дахь газар нь Төв аймгийг хариуцан ажилладаг бөгөөд тайлант хугацаанд тус газраас явуулах хяналт шалгалтын 2018 оны төлөвлөгөөг боловсруулж байгууллагын даргаар 2018.01.17-ны өдөр батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус төлөвлөгөөний дагуу ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газрын даргын баталсан нийт 8 удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт 5, төлөвлөгөөт бус 3 хяналт шалгалт зохион байгуулан нийт 12 ААН-ийн 260 гадаадын иргэн хамрагдсан бөгөөд дүнг тухай бүр холбогдох албан тушаалтанд танилцуулж ажиллалаа.

Өнөөдрийн байдлаар Төв аймагт 438 гадаадын иргэн бүртгэлтэй байгаа ба байнгын ажиллагаатай 12 ААН-ийг бүртгэлд хамруулан www.immigration.gov.mn/map сайтад мэдээлэл байршуулан, хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас өгсөн бичиг баримтын хуурмаглал шалгах төхөөрөмжийг ашиглан нийт 280 гадаадын иргэний бичиг баримтыг шалгав.

Орон нутгийн нислэгээр зорчиж буй нийт 606 гадаадын иргэний бичиг баримтыг шалгаж, гадаадын зарим иргэдэд 2017.07.01-ний өдрөөс Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.

1.6. Иргэний харьяаллын талаар:

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 13 иргэнээр өргөдөл-анкетыг бөглүүлэн холбогдох баримт бичгийг хуулбарлан авч Харьяатын газарт хүргүүлсэн.

1.7. Ярилцлагын тэмдэглэл болон баталгаа гаргуулан хил нэвтрүүлсэн талаар:

Монгол улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай зэрэг үндэслэлээр БНСВУ, Киргиз, Филиппин, Казакстан, БНАСАУ, БНЭУ зэрэг улсын нийт 584 гадаадын иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар:

Тайлант хугацаанд тус газрын дарга 14 тушаал батлан гаргасан ба тус газар 2018 онд хийх үндсэн арга хэмжээний төлөвлөгөө болон сар бүр хийх үндсэн арга хэмжээний төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөө, хяналт шалгалтын төлөвлөгөө, Төв аймаг дахь Цагдаагийн газар, Хилийн 0218-р анги зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө, тус газрын Ёс зүйн хорооноос 2018 онд хийх ажлын төлөвлөгөөг тус тус батлан гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд төвөөс өгсөн үүргийн дагуу дараах мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгжүүдэд хүргүүллээ. Үүнд:

- Тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр гаргаж БОНХ-т хүргүүлэв;
- Байгууллагын даргын Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд туссан тус газартай холбоотой арга хэмжээний биелэлт, байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлт, инфографик мэдээнд тусгах Буянт-Ухаа дахь газрын статистик тоог өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж сар бүр гаргаж БОНХ-т хүргүүлэв;
- Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах талаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлт, байгууллагын даргатай 2018 онд байгуулсан тус газрын даргын үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх илтгэх хуудас, байгууллагын даргын 2017 оны А/170 дугаар тушаалаар баталсан журмын биелэлтийг улирал бүр гаргаж БОНХ-т хүргүүлэв;
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд хуулийн төслийг боловсруулж буй ажлын хэсэгт тус газрын албан хаагчдаас санал авч нэгтгэн ЭЗГХХ-т тогтоосон хугацаанд хүргүүлсэн.
- Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу тус газрын үүрэг бүхий албан тушаалтнууд 2017 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ бөглөж, баталгааг ГИХГ-ын ЭБАТ-д 2018.02.01-ний өдөр хүргүүлсэн.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад бичиг баримтын хуурмаглал илрүүлэх төхөөрөмжөөр гадаадын иргэдийн материал шалгасан 2018 оны нэгдүгээр улирлын тайланг гаргаж тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд хоёрдугаар улирлын тайланг гаргаж хүргүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улсад зорчиж буй гадаадын иргэн, тэдгээрийг уригч аж ахуйн нэгж, байгууллагуудад салбарын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчилан таниулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Буянт-Ухаа боомтод өдөр бүр ГИХГ /төв/-аас Монгол, Англи хэл дээр бэлтгэн ирүүлсэн хэвлэмэл хуудсыг тарааж, видео шторкийг нислэгтэй үед тусгайлан бэлтгэсэн дэлгэц дээр гарган мэдээллээр ханган ажилласан.

Буянт-Ухаа дахь “Чингис хаан” олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд энэ онд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн 3 дугаар хурал 2018.01.23-ны өдөр хуралдаж нүүлгэн шилжүүлэх ажиллагааны төлөвлөгөөг баталсан ба уг төлөвлөгөөний дагуу 2018.11.07-оос 08-ны өдрүүдэд бүрэн нүүж үйл ажиллагаа жигдрэхээр төлөвлөгдсөн байна.

- ИНЕГ-ын даргын баталсан 2018.01.26-ны өдрийн А/43 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан ба дэд ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Буянт-Ухаа дахь газрын дарга, дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хяналтын улсын ахлах байцаагч З.Даваасүрэн нар орсон ба Дэд ажлын хэсгийн удирдамж, төлөвлөгөөг 2018.03.01-ний өдөр баталсан бөгөөд тус төлөвлөгөөний дагуу холбогдох ажлыг хийж байна.

- Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах, хамтран зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн 4-р хурал 2018.04.05-ны өдөр ИНЕГ-т зохион байгуулагдсан бөгөөд уг хурлаар ажлын хэсгийн нүүлгэн шилжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

- Тус газрын бие бүрэлдэхүүнд байгууллагын даргын 2018 оны Б/117, Б/118, Б/119, Б/120, Б/121 дүгээр тушаалын дагуу өөрчлөлт орсонтой холбогдуулан Хөшигийн хөндийн нисэх буудал руу нүүлгэн шилжүүлэх Буянт-Ухаа дахь газрын албан хаагчдын “А”, “В”, “С” нөөцөөр ангилсан ангиллыг шинэчлэн баталсан.

- Тагнуулын ерөнхий газрын Кибер аюулгүй байдлын газраас 2018.03.15-ны өдөр зохион байгуулсан хуралд ГИХГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга болон ерөнхий инженер нар оролцож шинэ нисэх буудалд суурилуулсан төрийн байгууллагуудын сүлжээний талаар хэлэлцсэн. ГИХГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн албан хаагчдын хамт 2018.05.28-ны өдөр сүлжээг шалгахад тус газрын харьяа өрөөнд интернет, IP утасны 2 сүлжээ орсон ба хэвийн ажиллаж байв.

- Тус газрын 3 албан хаагч 2018.06.13-ны өдөр Хөшигийн хөндийн нисэх буудал дахь хилийн хяналт шалгалтын баталгаажсан бүс, хяналт шалгалтын ерөнхий зарчим болон тус газар байрлахаар төлөвлөсөн ирэгч, явагчийн танхим дахь өрөөтэй танилцав.

Буянт-Ухаа дахь газрын 4 ээлжийн ахлахууд Даваа гариг бүр, нийт албан хаагчид 14 хоногт нэг удаа цуглаж тулгамдаж буй асуудлаа хэлэлцэн газрын даргаас үүрэг чиглэл авч ажилладаг ба ээлж тус бүр хагас жил, жилийн эцэст хийж

гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлангаар эмхэтгэл хийж, танилцуулга бэлдэн албан хаагчдад хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийн ажиллаж байна.

2.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар:

Бичиг хэрэгт 81 албан бичиг ирсэнийг бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 57 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 73 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Он \ Ангилал	Ирсэн бичиг	Явсан бичиг
2017 оны эхний хагас жил	36 /хариутай 18/	125
2018 оны эхний хагас жил	81/харицтай 57/	73

Тайлант хугацаанд тус газрын 2 албан хаагчаас ирүүлсэн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн, хариуг хүргүүлсэн бол иргэн, ААН, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол байхгүй болно.

Он \ Ангилал	Албан хаагчаас ирсэн өргөдөл, гомдол	Иргэн, ААН, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол
2017 оны эхний хагас жил	9	1
2018 оны эхний хагас жил	2	0

Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Буянт-Ухаа дахь газрын даргын батлан гаргасан тушаал, тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын 2018 он болон 01-06 дугаар сарын үндсэн арга хэмжээний төлөвлөгөө, түүний биелэлт, тайлан, ирсэн өргөдөл, гомдол энэ оны хяналт шалгалтын төлөвлөгөө, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө зэргийг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар:

ГИХГ-ын даргын 2017 оны Б/51-р тушаалаар тус газрын батлагдсан орон тоо 29 бөгөөд одоо ажиллаж буй 26, хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагч байгаа ба 11 албан хаагч баталсан хуваарийн дагуу ээлжийн амралтаа эдэлсэн.

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн програмд тус газрын албан хаагчдын мэдээллийг тухай бүр шинэчилэн ажиллаж байна. Үүнд:

- Байгууллагын даргын 2018 оны Б/69 дүгээр тушаалын дагуу өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн 1, Б/118, Б/119, Б/120, Б/121 дүгээр тушаалын дагуу тус газраас шилжин ажиллаж буй 4, нийт 5 албан хаагчийн мэдээллийг хассан;
- Байгууллагын даргын 2018 оны Б/35, Б/155 дугаар тушаалын дагуу албан тушаал дэвшүүлсэн 2 албан хаагчийн мэдээллийг шинэчилсэн;
- Байгууллагын даргын 2018 оны Б/153, Б/117 дугаар тушаалын дагуу тус газарт шилжин томилогдон ирсэн 2, Б/177 дугаар тушаалын дагуу шинээр томилогдон ирсэн 1, нийт 3 албан хаагчийн талаарх мэдээллийг шинээр оруулсан;
- Мэргэжлээ дээшлүүлсэн 2, тус програмд шинээр зэрэг дэв гэсэн цонх нээгдсэнтэй холбогдуулан төрийн захиргааны 21 албан хаагчийн мэдээллийг тус тус нэмж оруулав.

Ажлаас чөлөөлөгдсөн, шилжин ажилласан, шинээр томилогдон ирсэн албан хаагчтай ажил хүлээлцэх акт үйлдэж, шилжин явсан болон ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчаар тойрох хуудас зуруулсан болно.

Тайлант хугацаанд албан үүрэгтээ хайхрамжгүй хандан ажлын алдаа дутагдал гаргасан 3 албан хаагчид байгууллагын даргын 2018.02.06-ны өдрийн Б/23, Б/24, Б/25 дугаар тушаалаар “сануулах” сахилгын шийтгэл ногдуулсан бол албан даалгавар биелүүлээгүй, албан үүрэгтээ хайхрамжгүй хандан ажлын алдаа дутагдал гаргасан 1 албан хаагчид байгууллагын даргын 2018.05.30-ны өдрийн Б/170 дугаар тушаалаар тус албан хаагчийн албан тушаалын цалинг 3 сарын хугацаанд 20 хувиар бууруулах сахилгын арга хэмжээ авсан байна. Мөн 2018.05.18-ны өдөр төвөөс зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал тасалсан 3 албан хаагчийн Ёс зүйн хариуцлагын талоныг цоолсон.

Тус газрын Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан тус хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэх хүсэлтийг төвд хүргүүлээ.

Тус газрын бие бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан албан хаагчийн талаарх судалгааг шинэчлэн гаргаж холбогдох нэгжид тухай бүр хүргүүлсэн. Тухайлбал, албан хаагчдын гэр бүлийн талаарх судалгаа, нэмэх төрийн захиргааны албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгуулах санал, албан хаагчдын орон байрны талаарх судалгаа, тус газарт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 2018 оны шагналын нөөцөд бүртгүүлэх албан хаагчдын талаарх тодорхойлолтыг анкетийн хамт бүрдүүлж Тамгын газарт, тэмдэгийн судалгааг гаргаж БОНХ-т, тус газарт ашиглаж байгаа иж бүрэн хурууны хээ уншигч тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилгоор холбогдох судалгааг гарган төвд хүргүүлсэн. Мөн хилийн боомтод ажилласан хяналтын улсын байцаагч нарт 2019 онд урамшуулал олгуулах санал зэргийг гаргаж Тамгын газарт хүргүүлсэн.

Буянт-Ухаа дахь газрын албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх үүднээс 2018 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний дагуу тус газраас зохион байгуулсан дараах сургалтуудад албан хаагчдыг хамруулж, орсон сургалт бүрийг баримтжуулсан. Үүнд:

- Тээврийн прокурорын газартай хамтран “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар”, “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загвар”-ын талаар тус газрын 14 хяналтын улсын байцаагч нарт сургалтыг 2018.01.08-ны өдөр зохион байгуулсан;

- Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тус газрын 25 албан хаагчдад 2018.02.15-ны өдөр сургалт зохион байгуулсан;

- Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтран тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг болон Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн талаар тус газрын албан хаагчдад 2018.03.21-ний өдөр сургалт зохион байгуулан, сорилын шалгалт авч мэдлэгийн түвшинг дүгнэлээ. Сургалтад ГИХГ-ын 6, тус газрын 2, нийт 8 жолооч хамрагдсан;

- Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэс болон Эрүүгийн цагдаагийн III хэлтэстэй хамтран “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” талаар,

тус газрын Ёс зүйн хорооноос “Төрийн албан хаагчийн ёс зүй” талаар 2018.03.28-ны өдөр нийт 23 албан хаагчдад сургалт зохион байгуулсан;

- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын албатай хамтран “Зөв зохистой хооллолт” сэдвээр, ГИХГ-ын архивч-оператор Ч.Баасанжав “Баримт бичгийн стандарт”, “Хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүй” сэдвийн хүргээнд 2018.04.09-ний өдөр тус тус хичээл орж нийт 18 албан хаагч хамрагдсан;

- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын албатай хамтран “Хоол боловсруулах эрхтэний эмгэгийн үеийн хооллолт” сэдвээр 2018.05.24-ний өдөр 20 албан хаагчдад мэдээлэл хүргэв;

- Нислэлийн цагдаагийн газартай хамтран “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх”, Төрийн албан зөвлөлтэй хамтран “Төрийн албан хаагчийн харилцааны соёл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр 2018.06.11-ний өдөр 23 албан хаагчдад сургалт зохион байгуулж ажилласан байна.

Харин төвөөс зохион байгуулсан доорх сургалтуудад албан хаагчдыг хамруулав:

- Хяналтын улсын байцаагчийн эрх олгох сургалтад тус газрын 1 мэргэжилтэн батлагдсан хөтөлбөрийн дагуу 2018.01.15-2018.02.02-ны өдрүүдэд хамрагдсан;

- Удирдах ажилтнуудын мэргэжил арга зүйн ээлжит цугларалт 2018.02.26-аас 28-ны өдрүүдэд зохион байгуулагдсантай холбогдуулж тус газраас нийт 9 албан хаагч оролцсон;

- Хан-Уул дүүргийн Гал түймэр унтраах, аврах 30-р ангитай хамтран гамшгийн аюулын зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага сургуульд хэрхэн хамрагдаж оролцох талаар 2018.03.28-ны өдөр тус газрын 23 албан хаагч заавар, зөвлөгөө өгөв;

- АНУ-ын ЭСЯ-тай хамтран 2018.03.21-ний өдөр зохион байгуулсан “Баримт бичгийн хуурмаглалыг илрүүлэх нь”, “Бусдын баримт бичиг ашиглах залиланг илрүүлэх нь” сэдэвт сургалтад тус газрын 10 албан хаагч хамрагдсан;

- Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран 2018.05.04-ний өдөр зохион байгуулсан “Жендэрийн тухай үндсэн ойлголтууд” болон “Ажлын байран дахь бэлгийн дарамт” сэдэвт сургалтад тус газрын 20 албан хаагчдыг хамруулав;

- Боомт, орон нутаг дахь газар хэлтсүүдийн инженерүүдийн мэргэжил арга зүйн цугларалтад 2018.05.10-аас 11-ний өдрүүдэд зохион байгуулсан холбогдуулж тус газрын сүлжээний инженер хамрагдсан.

- Засгийн газрын 2018 оны 145, 146, 147 дугаар тогтоолоор баталсан журмууд болон “Зохион байгуулалт захирамжлалын баримт бичиг” сэдвээр 2018.06.08, 11-ний өдрүүдэд зохион байгуулсан сургалтуудад 23 албан хаагч хамрагдав.

Үүнээс гадна Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтуудад батлагдсан хувиарын дагуу тус газрын албан хаагчид хамрагдаж мэдлэгээ дээшлүүлэв.

Тайлант хугацаанд тус газрын албан хаагчдаас иргэд харилцан зорчих нөхцлийн талаар Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийн талаар сорилын шалгалт авч, албан хаагчдын мэдлэгийн түвшинг дүгнэлээ.

Байгууллагын даргын 2018 оны Б/57, Б/110 дугаар тушаалын дагуу тус газрын 2 албан хаагч байгууллагын захиалгаар ХСИСургууль болон Удирдлагын академид холбогдох сургалтад тус тус хамрагдсан бөгөөд ХСИСургуульд мэргэжил дээшлүүлсэн албан хаагч “Гэмт явдал судлал-эрх зүй”-н магистрын зэрэг хамгаалсан.

2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан. Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 281,223,900 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 142,010,612 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 17,397,177 төгрөг, ХУД-т цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 11,410,476 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 12,216,810 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажилласан.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2018.06.02-ны дотор гарган ХУД-ийн төрийн сангаар баталгаажуулан ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Мэдээгээр 227,705,600 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 184,716,490 төгрөгийн ажил үйлчилгээ явуулж өглөг авлагагүй ажилласан. НДШ-ийн тайлан гарган 2018.06.05-ны дотор НДХ-т хүргүүлэн тооцоо нийлэв.

Албан хаагчдад үнэт цаас болох визийн хуудас 1800 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон.

Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв. Хангамж, бараа материалын зардалд 12,216,810 төгрөгийн худалдан авалт хийж, албан хаагчдыг шаардлагатай бараа материалаар хангаж ажилласан.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 1,684,508 төгрөг, байрны түрээс 8,820,000 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс руу шилжүүлсэн.

Визийн тэмдэгтийн хураамж 151,062,440 төгрөг, визийн хуудас 22,389,540 төгрөгөөр тайлан нэгтгэн Хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан.

Түлш шатах тослох материалд өссөн дүнгээр 1,663,600 төгрөгний зарцуулалт гаргаж тайлагнасан.

Тус газрын 2018 оны нэгдүгээр улирлын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж 2018.04.12-ны өдөр Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

Тус газрын даргын баталсан 2018.06.04-ний өдрийн А/13 дугаар тушаалын дагуу Буянт-Ухаа дахь газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн 2018 оны эхний хагас жилийн тооллогыг 2018.06.04-өөс 08-ны өдрүүдэд явуулж бүртгэл хөтөлсөн бөгөөд дүнг тус газрын даргад мөн сарын 12-ны өдөр танилцуулсан.

Тус газрын 26 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.

Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг шивж оруулсан. Тухайлбал, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт

хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл зэргийг байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллав.

Үйлчилгээнд явж буй автомашины цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн батлагдсан маршрутын дагуу албан хаагчдыг тээвэрлэж, замын хуудсыг бөглөн санхүүтэй тооцоо нийлж ажилласан ба бүрэн засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллагаанд оруулсан. Үүнд:

- 93-84 УБН улсын дугаартай Приус-20 маркийн автомашинд шинээр мотор авч тавин, тос, шүүр, явах эд ангид 2 ширхэг босоо тэнцүүлэгч, 4 ширхэг наклад, салон болон моторын агаар шүүгч, трамбүлүрийн урд зөөлөвч резин 4 ширхэг, 1 их гэрэл, агаар цэвэршүүлэгчийг сольж янзалсан. Гадна үзэмжийн 14 детальд сэв гарган будаг хийсэн. Тус засвар үйлчилгээнд нийт 978,000 төгрөг зарцуулсан;
- 04-34 УБҮ улсын дугаартай Соната-7 маркийн автомашины амаржин 4 ширхэг, накладк 8 ширхэг, хойд гарны түлк 6 ширхэг, урд өндгөн тулгуур 2 ширхэгийг сольсон. Тус засвар үйлчилгээнд нийт 662,000 төгрөг зарцуулсан.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд дотоод сүлжээ, техник хэрэгслийн нийт 33 дуудлага хүлээн авч, засварласан ба “ISM” програмын шинэчлэлтийг бүх компьютерт хийн тус газрын “E-Office” програмыг ашиглах IP хаяг төвийн IP хаягаас өөр тул төвийн серверт NAT бичүүлж хэвийн ажиллагаанд оруулсан.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын бичиг баримтын хуурмаглал шалгах програм болон “Мэдээллийн аюулгүй байдал”-ын талаар гарын авлага бэлтгэн тус газрын албан хаагчдад танилцуулсан. Үүгээр тус газрын албан хаагчид өдөр тутамдаа хэрхэн өөрийн мэдээллээ хамгаалах, нууцлалтай хадгалах, халдлагад өртсөн тохиолдолд авах арга хэмжээ болон урьдчилан сэргийлэх талаар мэдлэгтэй болсон.

Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд байгууллагын цахим хуудсанд тус газрын танилцуулга, 2018 оны сар бүрийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, тайлан болон өргөдөл, гомдлын талаарх мэдээ, харин Immigration.gov.mn/mar сайтад Буянт-Ухаа дахь газрын объектын судалгааг байршуулав.

Тайлант хугацаанд тус газрын хэмжээнд ашиглагддаг нийт тоног төхөөрөмжийн судалгаа, Буянт-Ухаа боомт дахь ирэгч, явагчийн танхимд байрлах өрөө болон зааланд камер суурилуулахтай холбоотой тооцоо судалгааг хийж тус газрын дарга танилцуулсан ба байгууллагын хэмжээнд зохион байгуулсан онлайн хурлын бэлтгэл ажлыг ханган холболт хийн ажилласан бөгөөд тасалдал гаргалгүй хүргэлээ.

Харин 2018.05.15-ны өдөр Буянт-Ухаа боомтод хэсэгчилсэн тог тасрахтай холбогдуулан “ISM” сүлжээний ажиллагаа тасалдсан үед сүлжээний тохиргоо хийж аваарын системийг ажиллуулан сүлжээг хэвийн ажиллуулсан.

Түүнчлэн тус газрын ашигладаг “ISM” сүлжээ 2018.06.04-ний өдрийн 20:15 цагт тасарсантай холбогдуулан “IP” хаягийг сольж 192.168.197.240 хаяг болох Цахилгаан холбооны сүлжээ рүү шилжүүлэн 20:20 цагт хэвийн ажиллагаанд оруулав.

Мөн тус сүлжээ 2018.06.05-ны өдөр 20:10–22:40 цагийн хооронд тасарсантай холбогдуулан тус газар дотоод зохион байгуулалт хийж, нэмэлтээр 3 албан хаагчийг ажиллуулан Буянт-Ухаа боомтод ирэх чиглэлд зорчсон 138 гадаадын иргэн, явах чиглэлд зорчсон 73 гадаадын иргэнийг нэг бүрчлэн шалгаж, тэмдэглэл хөтөлж ажиллалаа.

Буянт-Ухаа боомтод дээр дурдсан өдрүүдэд сүлжээ тасарсантай холбогдуулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар байгууллагын даргад танилцуулж ажиллав.

Үүнээс гадна интернет сүлжээнд холбогдсон компьютерийн олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтууд /Facebook, Twitter, Youtube, Instagram, Steam гэх мэт/-ыг хаалгасан.

Гурав. Олон нийттэй харилцах чиглэлээр

Тус газар дор дурдсан нээлттэй хаалганы өдөрлөгө, сургалт болон цугларалтанд хамрагдаж байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгддэг тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл, ном товхимолын талаар үзэсгэлэн гаргаж, эрхлэх асуудлынхаа хүрээнд олон нийтэд зөвлөгөө мэдээлэл өглөө. Үүнд:

- “Аэро Монголиа” ХХК-ийн хүсэлтийн дагуу 2018.01.19-ний өдөр “Монгол Улсын визийн талаарх ойлголт” сэдвээр тус компанийн ажилчидад сургалт зохион байгуулсан.

- Тус газрын албан хаагчид төвийн бие бүрэлдэхүүний хамт 2018.02.02-ны өдөр ХХЕГ-т зохион байгуулсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний улсын төсөвт, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүн танилцуулах үзэсгэлэн”-д оролцсон;

- “Чингис хаан” олон улсын нисэх буудалд үйл ажиллагаа явуулдаг хууль хяналтын байгууллагуудтай хамтран “Үргэлж тантай хамтдаа”, “Нээлттэй үйлчилгээ” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгийг 2018.05.09, 21-ний өдрүүдэд зохион байгуулахад оролцсон.

- Төв аймгийн Засаг даргын Тамгын газраас 2018.04.02-ны өдөр тус аймгийн Цагдаагийн газрын сумын хэсгийн төлөөлөгч, Тамгын газрын хууль эрх зүйн ажилтнуудын дунд зохион байгуулсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт цугларалтад оролцсон.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, санхүүгийн талаарх мэдээлэл болон Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн “Шударга нийгмийн төлөө хамтдаа” гарчигтай 3 төрлийн зурагт хуудсыг тус газрын мэдээллийн самбарт байршуулж албан хаагч болон олон нийтэд албаны үйл ажиллагаа, үйлчилгээний талаар сурталчилав.

Дөрөв. Бусад

Буянт-Ухаа дахь газар нь дотоод үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор тус газрын үйл ажиллагааны талаарх статистик мэдээ агуулсан эмхэтгэлийн төслийг

бэлтгэв. Тус эмхэтгэлийн төсөлд Буянт-Ухаа боомтод олгосон виз, түр ирэгчийн бүртгэл, хасалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, захиргааны зөрчил, албадан гаргасан гадаадын иргэн, хил дээрээс буцаасан иргэний талаарх 2016, 2017, 2018 /2018 оны тоон мэдээг эхний хагас жилийн байдлаар тусгасан/ оны тоон мэдээг он, улс, зөрчлийн төрөл зэргээр ангилсан болно.

Үүнээс гадна байгууллагын чиг үүргийг “Чингис хаан” ОУ-ын нисэх буудалд хэрэгжүүлэхэд тус газрын албан хаагчид өдөр тутам гадаадын иргэдтэй харилцдаг тул боомтод өдөр тутам хэрэглэгддэг 200 орчим үг, өгүүлбэр оруулсан англи-монгол хэлний ярианы дэвтрийн төслийг боловсруулсан.

Дээр дурдсан эмхэтгэл болон англи-монгол хэлний ярианы дэвтэрт тус газрын даргаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг нэмж тусгасны дараа хэвлүүлж албан хаагчдад хүргэхээр ажиллаж байна.

Удирдах ажилтнуудын мэргэжил арга зүйн ээлжит цугларалтын үеэр зохион байгуулсан төв болон боомт, орон нутгийн багуудын аварга шалгаруулах спортын 4 төрөлт тэмцээнд тус газрын албан хаагчид амжилттай оролцож, шатрын аварга шалгаруулах тэмцээнд нярав Н.Алтанчимэг Тэргүүн байр, сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд эмэгтэй баг тамирчид алтан медаль, гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд эмэгтэй баг тамирчид мөнгөн медалийн эзэд болж, багийн нийлбэр дүнгээр II байр эзэллээ.

Үүнээс гадна Монгол орны цаг уурын эрс тэс уур амьсгалын нөлөөгөөр хаврын улиралд хүний дархлал сулардаг учир тус газрын албан хаагчдыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор витаминжуулалтын аяныг зохион байгуулсан ба В, С вирусын шинжилгээнд хамруулав.

ГИХГ-ЫН БУЯНТ-УХАА ДАХЬ ГАЗАР